

ISO/IEC JTC1/SC2/WG2 N4653

Title: Comments on Proposals of Zanabazar Square and Soyombo Script from Mongolian Experts
Source: suzuki toshiya (Hiroshima University, Japan), Takashi Matsukawa (Otani University, Japan) and Hitoshi Kuribayashi (Tohoku University, Japan)
Action: For consideration by JTC1/SC2/WG2
Type: Expert Contribution

On the end of December 2014, Takashi Matsukawa visited Mongolian experts; R. Otgonbaatar (The Institute of Language and Literature at Mongolian Academy of Sciences) and S. Demberel (Dept. of Philosophy and Religious Studies, National University of Mongolia), and informed the current status of the proposal of Zanabazar Square script (in PDAM2.2) and Soyombo script (WG2 N4414). Recently we received their comments on the standardization of these scripts, here we forward their comments.

As their initial response reported in WG2 N4613, they strongly request to postpone the standardization of these scripts, because further studies on the orthographies with each language are needed. It seems that even the name of the script “Zanabazar Square Script” should be reconsidered (in their comments, they use different name “Hevtee Durvuljin Script”).

Considering that Mongolia is a P-member in JTC1 and Mongolian experts are non-ignorable part of the user community of these scripts, the consensus with them is required to achieve the smooth interchange of the digital data of these scripts.

Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсгийн

стандартад өгөх санал

2015 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр

Монголчуудын бичиг үсгийн соёлын хосгүй үнэт өв Өндөр гэгээн Занабазарын “Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсгийн олон улсын стандарт”-д хүчин чармайлт гарган буй мэргэжилтэн та бүхний ажилд амжилт хүсье. Занабазарын Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсгийн **стандартад** дараахи саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Соёмбо үсгийн дүрс галигийг хийхдээ түүний бичлэгийн нарийн дэг ёс, зурлага, дараалал, тиг, хэмжээг анхааран үзэж **уламжлалт тиг, хэмжээг** судлах нь зүйтэй. Аншуман Пандейн төсөлд соёмбо үсгийн тиг, хэмжээс алдагдсан байна.
2. Өндөр гэгээний “Хэвтээ дөрвөлжин үсэг” нь “Соёмбо” үсгийн хурдан бичлэгийн хувилбар болж зохиогдсон тул дээрх үсгүүдийг хамтад нь судлаж нягт нарийн дүрс хэлбэр, галигийг нь дагалдуулан хийх .
3. Соёмбо үсэг нь санскрит, төвд, монгол хэлээр бичсэн ямар ч хэл бичгийн зохиолыг бүрэн төгс тэмдэглэхээр зохиосон тул дээрх хэлнүүдийн авиазүй, үгзүйг нарийвчлан оноох хэрэгтэй
 - Соёмбо үсгээр Монгол хэлээр бичсэн тохиолдолд монгол үсгийн зөв галиг гарах ёстой.
 - Соёмбо үсгээр Санскрит үг бичсэн тохиолдолд санскрит үсгийн зөв галиг байх ёстой
 - Соёмбо үсгээр Төвд үг бичсэн тохиолдолд мөн зөв галиг гарах ёстой. Хэвтээ дөрвөлжин үсэгт нь бүгд нэгэн адил хамаарах зүйл.

Ер Аншуман Пандей Соёмбо үсгийг голчлон санскрит, төвд хэлний авиа, үсэгтэй харьцуулсан бололтой. Харин Монгол хэлний авиазүй, үгзүйн дүрмийг төдийлөн нарийн тусгаагүй тал түүний судлагаанаас ажиглагдлаа. Соёмбо үсгээр монгол хэлний цагаан толгойн г, ж/з/, ч/ц/ гийгүүлэгчийг хэрхэн бичиж галиглан буулгах талаар тодорхой тусгах хэрэгтэй.

Соёмбо үсгээр монгол хэлээр босоо, хэвтээ бичих хоёр ёс, санскрит тарнийн үсэг бичих үед толгойтой болон толгойгүйгээр бичдэг үсгийг нарийн тооцон судлаж оруулах ёстой. Бас монгол улсын болон гадаадын холбогдох эрдэмтэн мэргэжилтний саналыг уралдуулмаар байна.

Монголчуудын бичиг үсгийн соёлын чухаг өв болсон Соёмбо болон Хэвтээ дөрвөлжин үсгийн олон улсын стандарт хэв галигчлалыг хийхдээ дээрх үсгүүдийн уламжлалт бичлэгийн дэс дараалал, тиг хэмжээг нарийвчлан судлаж, шинжлэх ухааны үндэслэлтэй судлагаан дээр тулгуурлан хийнэ гэдэгт найдаж байна. Иймд уг үсгийн стандартыг яаран батлахыг түр хойшлуулах санал илгээж буйг анхаарч үзэхийг хүснэ.

Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

эрдэм шинжилгээний ажилтан

МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхмийн багш

Р.Отгонбаатар

С.Дэмбэрэл

To: **International Standardization Council**

Subject: **Proposal to Soyombo and Hevtee Durvuljin Script Encoding Standard**

Date: 04.01.2015

Dear Madam/ Sir,

This is to express our deep gratitude for and wish every success in your enormous continuous efforts in promoting Soyombo and Hevtee durvuljin scripts as unparalleled cultural heritage of Mongolian literacy. Taking this advantage we would like to propose the following comment on encoding standards of Zanabazar's Soyombo and Hevtee durvuljin scripts:

1. To give a due consideration and conduct scientific research on traditional writing order, traits, dimensions, manuscript graphics, proportion of Soyombo script in encoding, given that there is some dimensional faulty of Soyombo script found in Anshuman Pandey's project.
2. Undur Gegeen's "Hevtee durvuljin script" being created as stenographic version of "Soyombo" script. Therefore, we should analyze and conduct research on its' dimension, form and encoding at same time.
3. Soyombo script being created for writing down literary works of Sanskrit, Tibetan and Mongolian in perfect way, hence should allocate/equivalent/ phonetics and word-lore of those languages.
 - If Mongolian words are written by Soyombo script, there should be the right transcription of Mongolian script adhered
 - If Sanskrit words are written by Soyombo script, there should be right transcription of Sanskrit script adhered
 - If Tibetan words are written by Soyombo script, there should be the right transcription of Tibetan script adhered /This issues should be also considered in Hevtee durvuljin script/

According to our observation Dr. Anshuman Pandey mainly compared Soyombo script with Sanskrit and Tibetan vowels and consonants, but he didn't emphasize phonetics, word-lore and Mongolian grammar in his research. He should have considered how to transcript consonants (г, ж/ з/, ч/ц) in Mongolian alphabet by Soyombo script.

We believe that research should be conducted on the horizontal and vertical writing methods of Soyombo script, while writing Mongolian words. Another comment we have is cases where Soyombo script is written by either head letter or without head letter and when transcript Sanskrit tantric manuscripts are used. We would like to seek for advice and comments on encoding Soyombo script from local experts and international scholars.

We hope that encoding and international standardization of Soyombo and Hevtee Durvuljin Script as unique heritage of Mongolian culture, should be considered and studied according to its traditional writing order, traits, dimensions and manuscript graphics of it and based on scientific research. Therefore, we would sincerely request you to consider our proposal of postponing of Soyombo and Hevtee Durvuljin Scripts encoding standardization until necessary research is conducted. Thank you for your kind cooperation.

Yours sincerely,

Otgonbaatar.R /Research worker in The Institute of Language and Literature at Mongolian Academy of Sciences/

Demberel.S /Lecturer in the Department of Philosophy and Religious studies, NUM/

(end of document)